




# 2022 оны IV улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан



# Агуулга

"ЛэндМН ББСБ" ХК-ийн 2022 оны IV улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

- **Зээлийн үйл ажиллагаа** 03 Зээлийн үйл ажиллагаа  
04 Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд
- **Бизнесийн үйл ажиллагаа** 05 Бизнесийн үйл ажиллагаа
- **Харилцагчийн үйл ажиллагаа** 18 Харилцагчийн үйлчилгээ
- **Санхүүгийн үйл ажиллагаа** 19 Санхүүгийн байдлын хураангуй тайлан  
20 Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
- **Эрсдэлийн удирдлага** 21 Эрсдэлийн удирдлага  
Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд
- **Компанийн засаглал** 22 Компанийн засаглал




## Зээлийн үйл ажиллагаа

✓ 2022 оны IV улиралд нийт харилцагч нартаа 122.5 тэрбум төгрөгийн дүнтэй 480.2 мянган зээлийг LendMN аппликейшнээр дамжуулан олгосон байна.

Түүнчлэн 2022 оны IV улирлын зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2022 оны III улиралтай харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 1.4%, олгосон зээлийн тоо 40.5%, олгосон зээлийн дүн 69.6%, зээлийн багц 43.0%-иар тус тус өссөн байна.

Энэ өсөлт нь ЛэндМН-ийн зээлийн үйл ажиллагаа улам бүр тэлж байгааг илэрхийлэх бөгөөд зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр 6 жилийн түүхэнд хамгийн дээд хэмжээнд хүрсэн амжилттайгаар ажиллалаа.

## 2022 оны IV улирлын үзүүлэлтийг өмнөх II, III улиралтай харьцуулсан байдал





## Зээлийн багцын чанарын үзүүлэлтүүд

2022 оны IV улиралд чанаргүй зээлийн багцад эзлэх хувь өмнөх улирлаас 30.7%-иар буурч 4.0% хүрсэн ба зээлийн эрсдэлийн сангийн нөөц 3.3 тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 116.2% хүргэж ажиллалаа.

Тэрбум төгрөг	2022.II	2022.III	2022.IV
<b>Нийт зээлийн багц</b>	<b>44.5</b>	<b>49.7</b>	<b>71.1</b>
Зээлийн эрсдэлийн сан	(3.0)	(3.4)	(3.3)
<b>Цэвэр зээлийн багц</b>	<b>41.4</b>	<b>46.3</b>	<b>67.8</b>
Хэвийн зээл	40.8	45.5	66.6
Хугацаа хэтэрсэн зээл	1.0	1.3	1.7
Чанаргүй зээл	2.7	2.9	2.9
Чанаргүй зээлийн багцад эзлэх хувь	6.0%	5.8%	4.0%
Эрсдэлийн сангийн хүрэлцээ	114.2%	119.3%	116.2%





## “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцааны ханшийн мэдээлэл



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2022 оны IV улирлын эцсийн байдлаар компанийн нэгж хувьцааны ханш 30.89 төгрөгөөр хаагдлаа.

### 2022 оны IV улиралд:

Нийт арилжаалагдсан ширхэг – 1.8 сая ширхэг  
Нийт арилжаалагдсан үнийн дүн – 50.2 сая төгрөг

Хувьцаа  
эзэмшигчдийн  
мэдээлэл




**7.6%**

Халаасны  
хувьцаа



**17.4%**

Олон нийт



**75.0%**

“Анд  
Системс” ХХК

Бизнесийн  
үйл ажиллагаа



## “ЛЭНДБОНД”-ийн өгөөжүүд үнэт цаасны дансанд байршлаа.

2022 оны 03-р сарын 31-ний өдөр арилжаалсан “ЛЭНДБОНД Транч-2”-ын өгөөж болох 233.1 сая төгрөг 2022 оны 10-р сарын 04-ний өдөр, 2021 оны 12-р сарын 02-ний өдөр арилжаалсан “ЛЭНДБОНД Транч-1”-ийн өгөөж болох 175.5 сая төгрөг 2022 оны

12-р сарын 02-ний өдөр тус тус үнэт цаасны дансанд байршлаа.

#ДижиталХөрөнгөОруулалт #ЛэндБонд  
#СанхүүгээЗөвУдирддагХүнБүртЗориулав



2022 оны 03-р сарын 31-ний өдөр арилжаалсан  
Транч 2  
**ЛэндБонд-ийн Өгөөж**  
2022.10.04-ний өдөр үнэт цаасны дансанд байршлаа



## Лэнд ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдлаа.

“ЛэндМН ББСБ” ХК-ийн охин компани “ЛэндМН Актив ТЗК” ХХК нь 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрлөө авч, улмаар 4.85 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүллээ.

Лэнд ХБҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны захиалга 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд амжилттай явагдаж, “Мөнгөний үнэ цэнээ өсгөө” гэсэн

уриан дор өгөөжөө сар бүр хүртэх боломжтой, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 17 хувийн өгөөжтэй Хөрөнгөөр баталгаажсан 48,500 ширхэг үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа андеррайтер төвтэйгээр олон нийтэд амжилттай арилжаалагдаж, захиалга хаагдсанаар нийт 299-н хөрөнгө оруулагчаас 4.85 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 100% амжилттайгаар, татан төвлөрүүлэхээр зорьсон өдрөөс 1 хоногийн өмнө биелсэн.

Энэхүү Лэнд ХБҮЦ нь зах зээлд эрэлт ихтэй байсны гол шалтгаан нь олон нийтэд нийт 5 удаа нээлттэй бонд санал болгосон “ЛэндМН ББСБ” ХК нь хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн санал болгодог, найдвартай компани гэдгийг илтгэсээр байна.

Лэнд ХБҮЦ үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа Монголын Хөрөнгийн биржээр арилжаалагдаж байгаа тул хараахан авч амжаагүй харилцагч та бүхэн хоёрдогч зах зээлээс авах бүрэн боломжтой юм.

Үнэт цаас гаргагч: "ЛэндМН Актив ТЗК" ХХК

# Лэнд ХБҮЦ

МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭЭ ӨСГӨӨ

Х

## ЗАХИАЛГА

# 100% БИЕЛЖ

амжилттай хаагдлаа.

Нийт үнийн дүн	Ширхэг	Тоо
4.85 тэрбум ₮	48,500	299

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч 	Ерөнхий андеррайтер 	Хамтрагч андеррайтер 
Хуулийн компани 	Хөрөнгө итгэмжлэн удирдагч 	Зээлийн шинжилгээ гаргагч 

Үнэт цаас гаргагч: "ЛэндМН Актив ТЗК" ХХК

# Лэнд ХБҮЦ

МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭЭ ӨСГӨӨ

Нийт үнийн дүн 4.85 тэрбум ₮	Хүү / жилийн/ 17%	Хугацаа 24 сар
Нэрлэсэн үнэ 100,000₮	Хүү төлөлт <b>САР БҮР</b>	
Захиалга авах хугацаа 2022.10.20-2022.10.26		

7707-0101, 7510-0575, 7771-6377



## Лэнд ХБҮЦ-ны эхний удаагийн хуваарьт өгөөж тараагдлаа.

“Мөнгөний үнэ цэнээ өсгөө” Лэнд Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас нь сар бүр өгөөж хуваарилах нөхцөлтэй арилжаалагдсан ба нийт хөрөнгө оруулагчдын хуваарьт өгөөжийг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд байршуулсан юм.

Хөрөнгө оруулагчид өгөөжөө өөрийн үйлчлүүлдэг брокерын компаниар дамжуулан авах боломжтой.

Лэнд ХБҮЦ  
Мөнгөний Үнэ Цэнээ Өсгөө

Хөрөнгөөр  
Баталгаажсан  
Үнэт Цаас  
гаргах зөвшөөрлөө авлаа

7707-0101, 7510-0575, 7777-6377

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч: lendmn  
Ерөнхий андеррайтер: RHINOS Investment  
Хамтрагч андеррайтер: ulZll&Co CAPITAL  
Хуулийн компани: MDSKhanLex  
Хөрөнгө итгэмжлэн удирдагч: UAF  
Зээлийн шинжилгээ гаргагч: [Logo]



Үнэт цаас гаргагч:  
“ЛэндМН Актив ТЗК” ХХК

## Лэнд ХБҮЦ

Мөнгөний Үнэ Цэнээ Өсгөө




Эхний удаагийн  
хуваарьт өгөөж

2022.12.12-ны өдөр

үнэт цаасны  
дансанд байршлаа.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч



Хуулийн компани



Ерөнхий андеррайтер



Хөрөнгө итгэмжлэн удирдагч



Хамтрагч андеррайтер



Зээлийн шинжилгээ гаргагч







Зээлээ хугацаандаа  
төлөөд

**Бонус**  
**2x**  
**Хоноо**

үржүүлж аваарай.



## Бонус оноо 2 дахин үржигдэх урамшууллын аян зарлалаа.

Харилцагчдад бонус оноо цуглуулах уян хатан нөхцөлийг санал болгох зорилгоор 1 сарын хугацаатай урамшууллын аян зарлан ажиллалаа. 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 12 дугаар сарын 09-ний өдрийн хооронд авсан зээлийн эргэн төлөлтөө хугацаандаа төлсөн тохиолдолд бонус оноог 2 дахин үржүүлэн олгосон юм. Харилцагч нартаа бонус оноогоо ашиглан зээлийн эрхээ нэмэх, хүүгээ бууруулах боломжийг бүрдүүллээ.

**Бонус**  
**2x**  
**Хоноо**





# Бизнесийн зээлийг LendMN-ээс

ЛэндМН Бизнесийн зээлтэй боллоо.


## lendbusiness

ЛэндМН зээлийн бүтээгдэхүүнийхээ төрлийг нэмж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн "Lend Business" зээлийн үйлчилгээгээ танилцууллаа.

Бизнесээ өргөжүүлэхэд санхүүгийн асуудал тулгарсан бол бид 1 тэрбум төгрөг хүртэлх зээлийг 24 хүртэлх сарын хугацаатай, 3-4 хувийн хүүтэйгээр санал болгож байна.

Бизнесээ санхүүжүүлэхийг хүсвэл  
77070101

Дэлгэрэнгүй мэдээллийг:  
<https://lend.mn/product.html>



1 ТЭРБУМ  
хүртэлх


24 сар хүртэлх  
Хугацаа

3-4  
Хүү



# LendMN аппликейшний “ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ”

ЦЭС ШИНЭЧЛЭГДЛЭЭ.



## Хөрөнгө оруулалт цэс шинэчлэгдлээ.

ЛэндМН-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ илүү өргөжиж “Хөрөнгө оруулалт”-ын бүтээгдэхүүний төрөл улам нэмэгдсэн.


Харилцагч та бүхэн “Хөрөнгө оруулалт” цэсээс:

- Lend Plus
- Lend Итгэлцэл
- Lend ХБҮЦ
- Lend Бонд
- Lend Хувьцаа

гэсэн бүтээгдэхүүний мэдээллийг дэлгэрэнгүй авах, мөнгөн хөрөнгөө өсгөх боломжуудтай танилцах боломжтой.

#СанхүүгээЗөвУдирдъя

#LendMN> #ХөрөнгөОруулалтЦэс



lendmn

“Lend Pay” худалдан авалтын үйлчилгээний маркетингийн хамтарсан идэвхжүүлэлтийн ажлууд хийгдлээ.

“Одоо баярлуулъя” уриатайгаар Lend Pay үйлчилгээний идэвхжүүлэлтийг Говь, Next electronics, Аз хур номын их дэлгүүр, Tech store, Цаатан годон гутлын их

дэлгүүр, Bananamall, Күнз боловсролын төв зэрэг мерчантуудтай маркетингийн хамтарсан идэвхжүүлэлтийн ажлуудыг хийж амжилттай ажиллалаа.



“Автомашинтай болох амархан -2” өдөрлөгт оролцлоо.



Автомарт авто худалдааны төвөөс уламжлал болгон зохион байгуулдаг “Автомашинтай болох амархан -2” өдөрлөг 2022 оны 11 сарын 24-с 11 сарын 27-ний хооронд зохион байгуулагдсан ба өдөрлөгийн үеэр банк бус санхүүгийн байгууллагууд, авто тээврийн үндэсний

төв нэг дор байрлаж зээлийн үйлчилгээг газар дээр нь шийдэх боломжтой байсан нь онцлог юм. Энэхүү өдөрлөгт ЛэндМН нь эко автомашины зээлийн үйлчилгээгээ танилцуулан ажиллалаа.





## “Философи, Хүний эрхийн уулзварт ТЕХНОЛОГИЙН ЁС ЗҮЙ” Философийн улсын XIV олимпиадыг ЛэндМН дэмжин хамтран ажиллалаа.



Философийн улсын олимпиад 14 дэх жилдээ Технологийн ёс зүй сэдвийн хүрээнд Монгол улсын Их дээд сургуулиудын дунд зохион байгуулагдсан юм. ЛэндМН нь Монголын хамгийн анхны финтек, технологийн компанийн хувьд нийгмийн хариуцлагынхаа хүрээнд

оюутан залуучуудад технологийн мэдлэг, цахим орчны ёс зүйн боловсролыг түгээх, хүний эрхийг дээдлэх үйлсэд хувь нэмрээ оруулан тус олимпиадыг ивээн тэтгэж хамтран ажиллалаа.

Боловсролыг дэмжигч:  
**lendmn**

**ФИЛОСОФИ, ХҮНИЙ ЭРХИЙН УУЛЗВАРТ:  
ТЕХНОЛОГИЙН ЁС ЗҮЙ**  
Философийн улсын XIV олимпиад

## ШУА Философийн хүрээлэнгийн үйл ажиллагааг дэмжин ажиллалаа.

Шинжлэх Ухааны Академи Философийн Хүрээлэнгийн 50 жилийн ойн ёслолын үйл ажиллаан дээр ШУА Философийн хүрээлэнгээс “Эрдмийн түнш” ергөмжлөлийг ЛэндМН гардан авлаа.

ЛэндМН нь ШУА Философийн хүрээлэнтэй Хөгжлийн төлөөх түншлэл тогтоож эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх чиглэлийн хүрээнд хамтран ажиллалаа.





## “Synth and Symphony” тоглолтын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллалаа.

ЛэндМН нь Монгол улсын филармони, ардын урлагийн уран бүтээлчид, продюсер, DJ нар, бийт мэйкерүүд гэсэн хөгжим бүтээгчдийн 100 орчим хүний баг бүрэлдэхүүнтэй зохион байгуулагдсан “Synth and Symphony” амьд хөгжмийн тоглолтын ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажилласан.

Амьд хөгжимд дурлагч залуус цугларсан нэгэн гайхалтай үдэш болж өнгөрсөн бөгөөд ЛэндМН нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулан ажилласан ба хамтын ажиллагааны хүрээнд тус

тоглолтод тоглогдсон 8 уран бүтээлийг бүх нөхцөлөөр үйл ажиллагаандаа ашиглах эрхийг авсан юм.



## “Ирээдүйг одооноос 2022” арга хэмжээнд оролцлоо.



ЛэндМН-ийн хамтрагч байгууллага болох Zochil онлайн худалдааны платформоос 2022 оны 11-р сарын 30-ны өдөр “Ирээдүйг одооноос 2022” арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд ЛэндМН бизнес эрхлэгч, онлайн худалдаа эрхлэгчдэд зориулсан “Lend Pay” үйлчилгээ болон “Lend Business” зээлийн үйлчилгээний мэдээлэл өгч



ажилласан юм. Арга хэмжээний үеэр бизнес эрхлэгчдэд онлайн худалдааны шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээллүүдийг солилцох, харилцаа холбоогоо өргөжүүлэх арга замуудыг нээх, орлогоо нэмэгдүүлэх, бизнесээ хөгжүүлэх, өргөжүүлэх боломжийг танилцууллаа.





THE GIFT  
УРАН САЙХНЫ КИНО

"ЛэндМН БСОБ" ХК-ийн 2022 оны IV улирлын санхүү, үйл ажиллагааны тайлан

Б.ЗАНБАЛДАН, Б.НАРАНБАТ, Б.ХҮСГЭН, О.НАРАНГЭРЭЛ, С.СҮХБААТАР, Ш.МӨНХНЭМ, О.ӨГӨВДЭЙ, Б.АМАРЖАРГАЛ, Х.САНЦАЛСҮРЭН, М.МЭНДСАЙХАН, Б.ОДБАЯР, Ч.БАЯРСАЙХАН, О.НАРАНГЭРЭЛ, Г.ЭРДЭНХҮҮ, С.СҮХБААТАР, Э.ЖИГЖИДСОН, Н.НАРАНТУЯА, Ж.МӨНХСАЙХАН, Э.ЭРДЭНЭДЭЛЭЙ, С.НАРАНБААТАР




## The Gift УСК-г ивээн тэтгэж, хамтран ажиллалаа.

ЛэндМН-ийн зүгээс эрхэм харилцагч нартаа ШИНЭ ЖИЛИЙН БЭЛЭГ болгон гэр бүл, найз нөхдөөрөө үзэх шинэ жилийн баярт зориулан бүтээсэн "The Gift" УСК-ны уран бүтээлчидтэй хамтран ажиллаж, ивээн тэтгэгч байгууллагаар ажиллалаа.





## МББСБХ-ТОЙ ТУНХАГ БИЧИГ БАЙГУУЛЛАА.



## МББСБХ-той тунхаг бичиг байгууллаа.

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооны түүхт 20 жилийн ойн баярын хурал ёслол төгөлдөр болж өндөрлөлөө. Энэ үеэр Холбооны гишүүд ололт, амжилтаа дүгнэж цэгнэн, ирэх жилүүдийн үйл ажиллагааныхаа чиглэлийг тодорхойллоо.

МББСБХ-оос гишүүн байгууллагуудаа уриалж Санхүүгийн зохицуулах хороо, Банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтарч “Монгол Улсад нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлж, ногоон зээлийг дэмжихийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”-ийг байгууллаа.







## ISO/IEC 27001:2013



ЛэндМН Мэдээллийн Аюулгүй Байдлын Менежментийн Тогтолцоо ISO/IEC 27001:2013 олон улсын стандартад нийцэж гэрчилгээ авлаа.

## ЛэндМН Мэдээллийн Аюулгүй Байдлын Менежментийн Тогтолцооны ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын гэрчилгээг албан ёсоор авлаа.

“ЛэндМН ББСБ” ХК нь 6 жилийн өмнө Монгол улсын зах зээлд анх удаа технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан Финтек бизнес моделийг LendMN аппликейшнээр дамжуулан амжилттай нэвтрүүлсэн түүчээлэгч байгууллага юм. ЛэндМН нь 2021 оны 2 дугаар сард Мэдээллийн Аюулгүй Байдлын Удирдлагын бодлогыг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулан өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжүүлж ажилласаар

байгаа нь Мэдээллийн аюулгүй байдлын Менежментийн Тогтолцоог бэхжүүлж ажиллаж байгааг илтгэж байна.

Тэр ч утгаараа ЛэндМН нь Мэдээллийн Аюулгүй Байдлын Менежментийн Тогтолцоо ISO/IEC 27001:2013 олон улсын стандартад нийцэн, 2022 онд “МонСертф” ХХК-аар баталгаажуулалтын аудит хийлгэж, албан ёсоор баталгаажуулалтын гэрчилгээг хүлээн авлаа.

ЛэндМН нь Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэнээр харилцагчийн мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байгаагийн гол илрэл юм. Бидэнтэй үргэлж хамт байж, үргэлж биднийг дэмжин ажилладаг харилцагч, хамтран ажиллагч байгууллагууддаа баярлалаа.

#АсааАсуудлааШийд





## Харилцагчийн үйлчилгээ

Харилцагчийн үйлчилгээний төв нь нийт 20 ажилтантайгаар ажилласан ба 2022 оны IV улирлын турш нийт 106,604 удаагийн харилцагчийн асуудлыг дуудлагын төв, сошиал суваг болон харилцагчийн үйлчилгээний төвөөр дамжуулан хүлээн авч тэдгээрийн 97.7%-д амжилттай үйлчлэн, харилцагчдад тулгарсан

асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байна.

2022 оны IV дүгээр улиралд дуудлагын төвөөр нийт 83,706 дуудлага хүлээн авч зээлийн үйлчилгээ, аппликейшн ашиглалт болон бусад үйлчилгээний талаарх мэдээллийг харилцагчдад тухай бүр нь түргэн шуурхай хүргэн ажиллажээ.

### Харилцагчийн үйлчилгээ

2022 оны IV улиралд хүлээн авсан

**83,706**

нийт дуудлага

**14** секунд

хүлээлгийн түвшин

Үйлчилгээ

**97.7** %

амжилттай хүргэсэн

Сошиал суваг болон

**22,898**

үйлчилгээний заалаар үйлчилсэн





## Санхүүгийн байдлын хураангуй тайлан

/Аудитлагдаагүй/

2022 оны IV улирлын байдлаар компанийн нийт хөрөнгийн хэмжээ 77.03 тэрбум төгрөг байгаагаас цэвэр зээлийн багц 67.79 тэрбум төгрөг, мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө 5.87 тэрбум төгрөг байна. Түүнчлэн өр төлбөр 49.95 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 27.08 тэрбум төгрөг байгаагаас хуримтлагдсан ашиг 15.76 тэрбум төгрөг байна.

### 2022 оны IV улирлын гол үзүүлэлтүүд

Нийт актив  
**77.03**  
тэрбум төгрөг

Нийт орлого  
**7.48**  
тэрбум төгрөг

Цэвэр ашиг  
**2.55**  
тэрбум төгрөг

Цэвэр зээлийн багц  
**67.79**  
тэрбум төгрөг

## Санхүүгийн байдлын тайлан

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2022.II	2022.III	2022.IV
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	2.02	2.34	5.87
Зээлийн багц (цэвэр)	41.44	46.28	67.79
Бусад хөрөнгө	1.77	2.27	2.38
Үндсэн хөрөнгө	0.74	0.69	0.59
Биет бус хөрөнгө	0.42	0.41	0.40
<b>Нийт хөрөнгө</b>	<b>46.40</b>	<b>51.99</b>	<b>77.03</b>


Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/	2022.II	2022.III	2022.IV
<b>Өр төлбөр</b>	<b>23.16</b>	<b>27.46</b>	<b>49.95</b>
Эх үүсвэр	20.37	24.59	40.64
Бусад өглөг	2.79	2.87	9.31
<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>23.23</b>	<b>24.53</b>	<b>27.08</b>
Хувьцаат капитал	8.48	8.48	8.48
Хоёрдогч өглөг	2.85	2.84	2.84
Хуримтлагдсан ашиг	11.91	13.21	15.76
<b>Нийт өр төлбөр болон эздийн өмч</b>	<b>46.40</b>	<b>51.99</b>	<b>77.03</b>

## Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Аудитлагдаагүй/


2022 оны IV улирлын байдлаар компанийн хүүгийн орлого өмнөх улиралтай харьцуулахад 51.7%-иар өсч 7.48 тэрбум төгрөгт хүрсэн бол цэвэр ашиг 2.55 тэрбум төгрөг буюу өмнөх улирлаас 97.7%-иар өссөн байна.

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2022.II	2022.III	2022.IV
Хүүгийн орлого	4.35	4.93	7.48
Хүүгийн зардал	(0.95)	(1.21)	(1.78)
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>3.40</b>	<b>3.72</b>	<b>5.70</b>
Зээлийн үйл ажиллагаатай холбоотой зардал	(0.98)	(0.98)	(1.14)
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(0.49)	(0.40)	(0.19)
<b>Үйл ажиллагааны цэвэр орлого</b>	<b>1.93</b>	<b>2.34</b>	<b>4.37</b>
Удирдлагын болон ҮА-ны зардал	(1.04)	(0.89)	(1.23)
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>0.89</b>	<b>1.45</b>	<b>3.14</b>
Татварын зардал	(0.12)	(0.16)	(0.59)
<b>Цэвэр ашиг</b>	<b>0.77</b>	<b>1.29</b>	<b>2.55</b>

Хүүгийн орлого, өссөн дүнгээр (тэрбум төгрөг)



Цэвэр ашиг, өссөн дүнгээр (тэрбум төгрөг)





## Эрсдэлийн удирдлага

“ЛэндМН ББСБ” ХК нь тайлант хугацаанд гадаад болон дотоод орчны эрсдэлийг дахин шинэчлэн үнэлж алба нэгжүүддээ эрсдэлийг үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж өгч, холбогдох журам заавраар хангахын сацуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд тайлагнан, шаардлагатай мэдээллээр хангаж ажилласнаар Эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэх, засаглалыг тасралтгүй сайжруулах үндсэн зорилгыг хэрэгжүүлсэн байна.

Зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллах зарчмын хүрээнд холбогдох журмуудыг дотоод үйл ажиллагаа болон хуулийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, үйл ажиллагаанд шаардлагатай шинэ журмыг боловсруулж ажиллалаа.

Жишээ болгон дурдвал: “МАБМТ-ын аудитын журам”, “Мэдээлэл технологийн өөрчлөлтийн удирдлагын журам”, “Мэдээллийн ил тод байдлын тухай журам”-г шинээр баталж мөрдөн ажиллаж байна. Үүний зэрэгцээ дотоод үйл ажиллагаа болон хуулийн шаардлагад нийцүүлэн “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, “Харилцагчийг таньж мэдэх, төлбөр тооцооны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааны журам”, “Нууцлалын журам” гэх мэт журмуудыг шинэчлэн баталж ажилласан байна.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2022 оны жилийн эцэст 1.87 тэрбум

төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.31 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Дээрх 3.31 тэрбум төгрөг нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 116%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2022 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

## Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2022.II	2022.III	2022.IV
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	41.6%	38.1%	28.1%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	47.3%	43.1%	31.5%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	43.9%	41.7%	31.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	8.7%	8.5%	12.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	-10.0%	-19.7%	-39.8%
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	37.1%	45.8%	78.5%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	44.5%	42.4%	38.0%

## Компанийн засаглал

“ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”) нь компанийн сайн засаглалын тэргүүн туршлагыг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж хувьцаа эзэмшигчдэдээ урт хугацааны үнэ цэнийг бий болгох, нэмэгдүүлэх, Компанид итгэх итгэлийг бэхжүүлэн ажиллахыг эрмэлздэг төдийгүй Монгол улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх, ил тод байдлыг хангах, нээлттэй тайлагнал, Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг дотоод журмаар нарийн нягт зохицуулах зэрэг зарчмуудыг баримталж, сайн засаглалын хэм хэмжээ, стандартыг бүрдүүлж ажилладаг.

### Төлөөлөн удирдах зөвлөл

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”) нь 2022 оны IV улиралд 2 удаагийн ээлжит хурал болон 1 удаагийн эчнээ санал хураалтыг зохион байгуулж, холбогдох асуудлуудыг хэлэлцэн шийдвэр гаргав. ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэрүүдийг холбогдох журамд заасны дагуу Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудлуудаас тоймлон хүргэвэл:

- 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн эчнээ санал хураалтаар Компанийн 2022 оны санхүүгийн тайланд

Монгол Улсын хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагаар “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК-ийг сонгож шийдвэрлэв.

- 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн эчнээ санал хураалтаар Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор үнэт цаас хаалттай хүрээнд санал болгон гаргахаар шийдвэрлэв.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүтэц, бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна:

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Б.Итгэл, гишүүдээр С.Энх-Амгалан, В.Баярсайхан, Д.Галхүү, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ нар ажиллаж байгаа бол ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Ж.Жаргалсүрэн, гишүүдээр С.Боргил, О.Болдбаатар харин ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны даргаар С.Энх-Амгалан, гишүүдээр С.Боргил, Д.Галхүү нар тус тус ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо болон Аудитын хороо нь 2022 оны IV улиралд тус бүр 2 удаа буюу 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр, 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр тус тус хуралдаж,



Компанийн үйл ажиллагаа, эх үүсвэр, дотоод аудиторын дүгнэлт, Компанийн 2022 оны санхүүгийн тайланд Монгол Улсын хуулийн дагуу хөндлөнгийн аудит хийх байгууллагын тухай хэлэлцсэн байна.

ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо нь 2022 оны IV улиралд 1 удаа буюу 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдсан байна.



**ВЕБСАЙТ:**

[www.lend.mn](http://www.lend.mn)

**УТАС:**

7707-0101

**ИМЭЙЛ:**

[board@lend.mn](mailto:board@lend.mn)